



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/250

Сүхбаатар сум

Хөсөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "а", 29.2, Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, 3.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Сэлэнгэ аймаг Сүхбаатар сумын Тохижилт үйлчилгээний газрын ажилчдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор шаардагдах төсөв хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2.Зардалд шаардагдах 1500000 /Нэг сая таван зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

3.Зардлын тайланг 2019 оны 08 дугаар сарын 15-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Ц.Уранцэцэг/-т ирүүлэхийг Сүхбаатар сумын Тохижилт үйлчилгээний газрын дарга /Ц.Насантогтох/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ